



# КОРОНАВИРУС БА ЭДИЙН ЗАСАГ

1 сар




Улаанбаатар хот  
2021.02.19

## Коронавируст халдварын нөхцөл байдал

Дэлхий нийтээр 2020 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн байдлаар коронавируст халдвараар 107.8 сая хүн өвчилж, 2.4 сая хүн нас барсан байна.

Нийт батлагдсан тохиолдлын 44.6 хувь нь Америкийн бүс нутгийн орнуудад, 33.7 хувь нь Европын орнуудад, 12.2 хувь нь Зүүн Өмнөд Азийн улс орнуудад, 5.6 хувь нь Газар дундын тэнгисийн зүүн бүсэд, 2.5 хувь нь Африкийн улс орнуудад, 1.4 хувь нь Номхон далайн баруун бүсэд тус тус бүртгэгдсэн.

Зураг 1. Коронавируст халдварын тохиолдлын тоо, өссөн дүнгээр



Эх үүсвэр: World Health Organization

Дэлхийн хэмжээнд нийт 88 бүс нутаг, улс оронд 160.6 тун вакциныг хийгээд байгаагаас Израйл улс хамгийн өндөр буюу нийт хүн амын 68.1 хувийг вакцинжуулаад байна. Харин Англи улс хүн амынхаа 21.8 хувь, АНУ 14.0 хувь, БНХАУ 2.9 хувь, ОХУ 2.9 хувийг тус тус вакцинд хамруулаад байна (Financial times).

Вакцинжуулалт эхэлснээр коронавируст халдварын тархалт өндөр байсан улс орнуудад халдварын тохиолдол буурч эхэлж байна. Монгол Улсын хувьд эсрэгээрээ, халдварын тархалт эрчимтэй нэмэгдэж байна.


Коронавируст халдварын тохиолдол Монгол Улсад 2020 оны I сарын байдлаар нийт 1779 болов. 2020 оны II сарын 13-ны өдрийн байдлаар 2293 болсон нь 1 дүгээр сартай харьцуулахад 13 хоногийн дотор 514 тохиолдол буюу 28.9 хувиар өсжээ.

2020 оны 1 дүгээр сард шинээр нэмэгдсэн тохиолдлуудын 23.4 хувь нь 0-19 насныхан, 48.6 хувь нь 20-44 насныхан, 28.0 хувь нь 45-аас дээш насныхан байна.

## Макро эдийн засаг дахь өөрчлөлт

Олон улсын валютын сангийн 2021 оны 01 дүгээр сарын төсөөллөөр энэ онд дэлхийн эдийн засаг 5.5 хувиар өсөхөөр тооцоолсон байна. Үүнд манай улсын гадаад худалдааны гол түнш орнууд болох БНХАУ-ын эдийн засаг 8.1 хувь, Орос улсынх 3.0 хувь, Япон улсынх 3.1 хувь тус тус өсөх төлөвтэй байна.


Зураг 2. Эдийн засгийн ялгаатай төсөөллүүд: Хөгжилтэй орнууд, хөгжингүй орнууд болон хөгжиж буй орнуудын Дэлхийн Эдийн Засгийн тоймын таамаглал, хувиар



Дэлхий нийтээр цар тахлыг хяналтдаа авахын тулд олон талт хамтын ажиллагааг идэвхжүүлэх нь чухал болоод байна. Олон улс орнууд, ялангуяа бага орлоготой орнууд цар тахлын үед өрийн хямралд орох хандлагатай байна. Иймд КОВАКС вакцины санхүүжилтийг нэмэгдүүлж, бүх улс орнуудад боломжит үнээр вакциныг хүргэх чиглэлд хамтран ажиллах шаардлагатай тулгарч байна<sup>1</sup>.

**Монгол Улсын эдийн засаг 2020 оны урьдчилсан гүйцэтгэлээр өмнөх оноос 1.0 их наяд төгрөг буюу 5.3 хувиар агшсан байна.** Үүнд хөдөө аж ахуйн салбарын нэмэгдэл өртөг өмнөх оноос 6.2 хувиар нэмэгдсэн хэдий ч уул уурхай, олборлох салбарынх 9.4 хувиар, аж үйлдвэр, барилгын салбар 1.1 хувиар, үйлчилгээний салбар 7.1 хувиар, бүтээгдэхүүний цэвэр татвар 9.8 хувиар түс түс буурсан нь нөлөөлжээ.


Зураг 3. Улирлын нөлөөллийг арилгасан ДНБ, 2010 оны зэрэгцүүлэх үнээр, тэрбум төгрөг



<sup>1</sup> Олон Улсын Валютын Сан, Дэлхийн Эдийн Засгийн Шинэчилсэн Тойм, 2021 оны 01-р сар

2017 оны I улирлаас 2019 оны II улирал хүртэл өсөлттэй байсан манай улсын эдийн засагт 2019 оны XII сараас Хятад улсад бүртгэгдэж эхэлсэн цар тахал маш хурдацтай нөлөөлж, улирлын нөлөөллийг арилгасан ДНБ 2020 оны I улиралд өмнөх улиралтай харьцуулахад 6.3 хувиар буурсан байна. Эдийн засгийн энэхүү хямралын эсрэг “Ногоон гарц” түр журмыг хэрэгжүүлэн, хилийн боомтуудын үйл ажиллагааг жигдрүүлснээр 2020 оны IV улиралд I улиралтай харьцуулахад уул уурхай олборлох салбар 2.0 дахин, хөдөө аж ахуйн салбар 3.5 дахин, үйлчилгээний салбар 1.3 дахин өсжээ. Харин импортоор орж ирэх бүтээгдэхүүн бүүрснаас шалтгаалан бүтээгдэхүүний цэвэр татвар 27.6 хувиар буурсан байна.

Зураг 4. ДНБ, үйлдвэрлэлийн аргаар, оны үнээр, тэрбум төгрөг



Манай улсын ХАА-н салбарт цаг уур, байгалийн хүчин зүйлсийн нөлөө ихтэй хэдий ч 2017-2020 онд тогтмол өсөлт үзүүлэн, 2020 онд өмнөх оноос 6.2 хувиар өсч, эдийн засгийн өсөлтийн 0.8 пунктийг бий болгов.

Уул уурхай, олборлолтын салбарын нэмэгдэл өртөг, 2010 оны зэрэгцүүлэх үнээр, 2020 онд 3.6 их наяд төгрөг болж, өмнөх оноос 9.4 хувиар буурахад 2020 оны I, II улиралд нүүрсний экспорт буурсан нь голлон нөлөөлсөн байна. Уул уурхайн бүтээгдэхүүний үйлдвэрлэл нь тээврийн салбарт шууд нөлөөлдөг бөгөөд бүх төрлийн тээврийн орлого өмнөх оноос 26.4 хувиар буурсан байна.

Аж үйлдвэр, барилгын салбарын нэмэгдэл өртөг, 2010 оны зэрэгцүүлэх үнээр, 2020 онд 2.4 их наяд төгрөг болж, өмнөх оноос 1.1 хувиар буурав.

Үйлчилгээний салбарын нийт нэмэгдэл өртөг, 2010 оны зэрэгцүүлэх үнээр, 7.4 их наяд төгрөг болж, өмнөх оноос 7.1 хувиар буурлаа. Уг бүүралтад бөөний болон жижиглэн худалдааны салбарын нэмэгдэл өртөг 11.1 хувиар, зочид буудал, байр сууц болон нийтийн хоолны үйлчилгээнийх 29.7 хувиар буурсан нь голлон нөлөөлсөн байна.

Эцсийн хэрэглээ талаас авч үзвэл, 2020 онд өнгөрсөн онтой харьцуулахад өрхийн хэрэглээ 2.7 хувь өссөн бол засгийн газрын хэрэглээ 16.0 хувиар өсөж, нийт эдийн засгийн өсөлтийн 3.8 хувиар дэмжсэн байна. Өрхийн хэрэглээ бодит хэмжээгээр тасралгүй өсөж, 2020 оны эцэст 2017 оноос 26.8 хувиар нэмэгдсэн байна. Засгийн газраас явуулж буй хөтөлбөрүүдийн үр дүнд өрхийн хэрэглээний өсөлт нь эдийн засагт эерэг нөлөөллийг авчирч байна.


Хөрөнгийн хуримтлал 2020 онд өмнөх оноос 11.8 хувиар буурч, эдийн засгийн өсөлтийг 19.3 хувиар сааруулав.

Цар тахлын үед импортын хэмжээ буурч, экспортыг хэвийн үргэлжлүүлж чадсанаар цэвэр экспорт эдийн засгийн өсөлтийг 10.1 хувиар дэмжсэн байна.

Дотоодын эдийн засаг эргэн сэргэх үйл явц нь коронавируст өвчлөлийг хяналтдаа авч, вакцинжуулалтыг эрт эхлүүлэх, эцсийн хэрэглээг үргэлжлүүлэн дэмжих, ГШХО-ыг нэмэгдүүлэхээс ихээхэн хамааралтай байна.

Гадаад худалдааны нийт бараа эргэлт 2020 оны I сард 1.1 тэрбум америк долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 17.8 хувиар өсөж, тэнцэл 181.1 сая америк долларын ашигтай гарлаа. Экспорт эргэн тогтворжиж байгаа ч эдийн засаг хэвийн үргэлжилж байсан 2019 оны дундажтай харьцуулахад импорт 11.3 хувиар бага байна.

Зураг 5. Уул уурхайн гаралтай экспортын гол нэрийн бараа бүтээгдэхүүн, сая америк доллароор, улирлаар



Эдийн засгийн өсөлт суларсан 2020 оны I улиралд уул уурхайн гаралтай экспортын гол нэрийн бүтээгдэхүүнүүд болох нүүрсний экспортын орлого 2.5 дахин, алтны экспортын орлого 2.4 дахин, зэсийн баяжмалын орлого 1.4 дахин тус тус буурчээ.

Цар тахлын нөлөөгөөр дэлхийн эдийн засаг агшиж, аж үйлдвэрлэл хумигдсанаас шалтгаалан түүхий эдийн эрэлт болон үнэ буурах эрсдэлтэй байна.


Төлбөрийн тэнцэл 2020 оны урьдчилсан гүйцэтгэлээр 786.9 сая америк доллар болж дунджаар ДНБ-ий 6.1 хувьтай тэнцэх ашигтай гарав. Үүнд урсгал дансны алдагдал 433.0 сая америк доллар болж, өмнөх оноос 1.7 тэрбум америк доллароор, хөрөнгийн дансны тэнцэл 105.8 тэрбум америк доллароор болж өмнөх оноос 55.0 сая америк доллароор, санхүүгийн дансны тэнцэл 1.3 тэрбум америк доллар болж, өмнөх оноос 1.4 тэрбум америк доллароор тус тус буурчээ.

## Үйлдвэрлэлийн салбарууд

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2021 оны 1 дүгээр сарын урьдчилсан гүйцэтгэлээр 1.6 их наяд төгрөг болж, өмнөх сараас 11.8 хувиар буурлаа.

Коронавируст цар тахал дэгдсэн үеэс эхлэн манай улсын боловсруулах үйлдвэрлэл, уул уурхайн олборлолтод нөлөөлж, 2020 оны эхний 5 сар дараалан аж үйлдвэрийн салбар уналттай байв. Макро эдийн засгийг тогтворжуулах хөтөлбөрүүдийн үр дүнд үйлдвэрлэл сэргэж эхэлсэн ч 2020 оны 11 дугаар сараас бүх нийтийн бэлэн байдалд шилжсэн нь эргээд үйлдвэрлэлийг хумьж байна.

Зураг 6. Аж үйлдвэрлэлийн салбарын нийт үйлдвэрлэл, сараар, тэр бум төгрөг




Аж үйлдвэрийн салбарын энэхүү агшилт нь боловсруулах аж үйлдвэрийн салбарт самнасан ноолуур, ноолууран сүлжмэл эдлэл, металл бэлдэц зэрэг гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлд хамгийн ихээр нөлөөлж, эдийн засаг уналттай байсан өмнөх оны мөн үеэс үйлдвэрлэл 15.0-70.6 хувиар, ажиллагсад буурсан 8.3-52.1 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Хамгийн их агшилттай байсан боловсруулах үйлдвэрлэлийн салбарууд, 2020 оны I сарын байдлаар, өмнөх оны мөн үетэй харьцуулахад, хувиар

Салбар	Нийт үйлдвэрлэл	Ажиллагсад
Ээрэх, нэхэх, даавуун материал бэлтгэх үйлдвэрлэл	-70.6	-52.1
Хувцас үйлдвэрлэл	-70.1	29.8
Арьс, арьсан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	-41.5	-33.4
Металл боловсруулах үйлдвэрлэл	-15.0	-8.3

Худалдааны салбарын нийт борлуулалт 2020 оны эцэст 22.0 их наяд төгрөг болж, өмнөх оноос 6.9 хувиар буурав. Үүнд жижиглэн худалдааны борлуулалтын орлого 13.7 их наяд төгрөг болж, өмнөх оноос 8.1 хувиар, бөөний худалдааны борлуулалтын орлого 8.3 их наяд төгрөг болж, өмнөх оноос 5.0 хувиар тус тус буурсан нь нөлөөлсөн байна. Тус салбарт ажиллагсад 2020 онд ойролцоогоор 5 хувиар буурсан байна.

Зураг 7. Худалдааны салбарын нийт борлуулалт, тэрбум төгрөгөөр




Цар тахлын улмаас бүх нийтийн хөл хорионд шилжсэн 11 дүгээр сард худалдааны салбарын борлуулалт өмнөх сараас 17.1 хувиар, өмнөх оны мөн үеэс 11.2 хувиар буурчээ.

**Нийтийн хоолны салбарын 2020 оны нийт орлого 451.2 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 7.0 хувиар, ажиллагсад 23.8 хувиар буурлаа.**

Уг салбарт рестораны орлого өмнөх жилтэй харьцуулахад 1.0 хувиар буурсан буюу бараг өөрчлөлт ороогүй бол кафены орлого 29.4 хувиар, баарны орлого 47.8% хувиар, гуанзных 20.3 хувиар тус тус буурчээ.

Зураг 8. Нийтийн хоолны салбарын орлого, тэрбум төгрөг




Мөн нийтийн хоолны салбарт ажиллагсдын тоо 2020 онд өмнөх оноос 23.8 хувиар буурсан байна. Үүнд захиалгат хоол хүргэлтийн үйлчилгээний ажилчид 63.4 хувиар, кафены ажилчид 53.8 хувиар, баарын ажилчид 37.8 хувиар, гуанзны ажилчид 17.2 хувиар, рестораны ажилчид 11.0 хувиар тус тус буурсан нь нөлөөлжээ.

**Зочид буудлын салбарын орлого 131.4 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оноос 55.9 хувиар, ажиллагсад 29.1 хувиар буурсан байна.**

3 ба түүнээс дээш одтой зочид буудлын орлого 2020 онд өмнөх оноос 64.7 хувиар, 2 одтой зочид буудлын орлого 39.6 хувиар, зэрэглэлгүй зочид буудлын орлого 23.1 хувиар буурсан байна.

Зураг 9. Зочид буудлын салбарын орлого, тэрбум төгрөг



## Мөнгө, санхүү, үнэ

Улсын нэгдсэн төсвийн нийт орлого, тусламжийн хэмжээ 2021 оны 1 дүгээр сарын урьдчилсан гүйцэтгэлээр өмнөх оны мөн үеэс 7.3 хувь, нийт тэнцвэржүүлсэн орлого, тусламж 6.0 хувиар тус тус буурсан бол нийт зарлага, цэвэр зээлийн хэмжээ өнгөрсөн оны мөн үеэс 22.3 хувиар өссөн байна.

Тэнцвэржүүлсэн орлого, тусламжийн хэмжээ буурахад татварын бус орлого 9.7 тэрбум төгрөг буюу 18.6 хувиар өссөн хэдий ч татварын орлого 52.1 тэрбум төгрөгөөр буюу 7.9 хувиар буурсан нь нөлөөлсөн байна. Монгол Улсад энэ оны 1 дүгээр сард 3.5 тэрбум төгрөгийн тусламжийн орлого оржээ.

Улсын нэгдсэн төсвийн зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээлийн хэмжээ 2021 оны 1 дүгээр сарын байдлаар 784.5 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 143.2 (22.3%) тэрбум төгрөгөөр өссөн байна. Зарлагын өсөлтөд урсгал зардал 128.5 (22.8%) тэрбум төгрөг, хөрөнгийн зардал 13.4 (16.7%) тэрбум төгрөгөөр өссөн нь нөлөөлжээ.

Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдал 2021 оны 1 дүгээр сарын урьдчилсан гүйцэтгэлээр 118.5 тэрбум төгрөг болсон нь 2018 оноос хойш 1 дүгээр сард анх удаа алдагдалтай гарсан жил болоод байна. Уг алдагдлын 75.3 тэрбум төгрөг (63.5%)-ийг Засгийн газрын гадаад зээлээр санхүүжүүлсэн байна.

*Хүснэгт 2. Төсвийн тэнцлийн үндсэн харьцаа, урьдчилсан гүйцэтгэлээр, улирлаар, хувиар*

Хугацаа		Орлого/ДНБ	Зарлага/ДНБ	Тэнцэл/ДНБ
2019	I	27.2	24.7	2.4
	II	28.0	28.0	0.0
	III	29.5	26.5	3.0
	IV	31.9	44.5	-12.6
	Жилийн гүйцэтгэл	29.3	31.3	-2.0
2020	I	27.6	31.2	-3.7
	II	21.8	42.5	-20.7
	III	27.0	32.7	-5.6
	IV	25.9	43.0	-17.1
	Жилийн гүйцэтгэл	25.5	37.8	-12.3

Улсын төсвийн орлого, ДНБ-ны харьцаа 4 улирал дараалан буурч байгаа бол эсрэгээрээ, төсвийн зарлага, ДНБ харьцаа өсөж, төсвийн тэнцлийн алдагдал 2020 оны урьдчилсан гүйцэтгэлээр ДНБ-ний 12 хувьтай тэнцэж, 2019 оноос 10 пунктээр нэмэгдсэн байна.

**Мөнгөний нийлүүлэлт 2021 оны 1 дүгээр сарын эцэст өмнөх оны мөн үеэс 3.6 (17.7%) их наяд төгрөгөөр өсөж, 24.2 их наяд төгрөг болов.**


Мөнгөний нийлүүлэлтийн 56.3 хувийг төгрөгийн хадгаламж, 19.0 хувийг валютын хадгаламж, 13.0 хувийг төгрөгийн харилцах, 8.7 хувийг валютын харилцах, 3.1 хувийг хадгаламжийн байгууллагуудаас гадуурх мөнгө эзэлж байна.

Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө 2021 оны 1 дүгээр сарын эцэст 1.0 их наяд төгрөг болж, өмнөх сараас 15.2 (1.5%) тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 168.9 (20.2%) тэрбум төгрөгөөр өсжээ.

Нийт зээлийн өрийн үлдэгдэл 2021 оны 1 дүгээр сарын эцэст 17.2 их наяд төгрөг болж, өмнөх сараас 25.0 (0.1%) тэрбум төгрөгөөр өсөж, өмнөх оны мөн үеэс 844.7 (4.7%) тэрбум төгрөгөөр буурсан байна.



Зураг 10. Чанаргүй зээл, нийт зээлийн харьцаа




Банкны систем дэх чанаргүй зээл, нийт зээлийн харьцаа манай улсад дотоодын халдвар бүртгэгдэж эхэлсэн 3 дугаар сараас эхлэн өсөж, 2021 оны 1 дүгээр сарын байдлаар 11.7 хувьд хүрч, өмнөх оны мөн үеэс 1.5 пунктээр өссөн байна.

**Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2021 оны 1 дүгээр сард өмнөх оны мөн үеэс 2.4 хувь, өмнөх сараас 1.0 хувиар өсөв.** Үүний 2.2 нэгж буюу 91.7 хувь нь хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнийн өсөлтөөс шалтгаалсан байна.

Мах махан бүтээгдэхүүний үнэ өвлийн сарууд болох 11, 12 дугаар сард буурч, 2 дугаар сараас эхлэн өсөх хандлагатай байдаг байсан бол коронавируст халдварын дотоодын тархалт, бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбоотойгоор мах, махан бүтээгдэхүүний үнийн өсөлт эрт явагдаж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2020 оны 11 дүгээр сард 6.6 хувь, 12 дугаар сард 9.7 хувь өссөн байна.

Зураг 11. Мах, махан бүтээгдэхүүний үнийн индекс, өмнөх оны мөн үетэй харьцуулснаар, хувиар, сараар




## Хөдөлмөр эрхлэлт, өрхийн орлого, нийгмийн халамжийн үйлчилгээ

**Ажиллах хүчний судалгааны 2020 оны IV улирлын дүнгээр ажиллах хүч 1.2 сая, үүнээс 92.4 хувь нь ажиллагчид байна.**


Хүн амын эдийн засгийн идэвх 2018 оны II дүгээр улирлаас хойш тасралтгүй буурч 2020 оны IV дүгээр улиралд 2018 оны I дүгээр улиралтай харьцуулахад ажиллах хүч 3.9 хувиар буюу 49.1 мянган хүнээр, ажил хайхаар бүртгүүлсэн иргэдийн тоо 23.5 хувиар буурсан байна.

Зураг 12. Ажиллах хүчний өөрчлөлт, улирлаар, хувиар, 2018.I=100



Хөдөлмөрийн нөөцөд ажиллагчдын эзлэх хувь буюу хөдөлмөр эрхлэлтийн түвшин 2020 оны IV улиралд улсын дунджаар 52.7 хувь, эрэгтэйчүүдэд 60.4 хувь, эмэгтэйчүүдэд 46.1 хувьтай байна. Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хөдөлмөрийн зах зээл дээрх оролцоо 14.3 пунктийн зөрүүтэй байгааг коронавируст халдварын тархалтаас урьдчилан сэргийлж, сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагааг цахимжуулсан нь эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэх боломжийг хязгаарлаж байгаагаар тайлбарлаж болох юм.


Зураг 13. Хөдөлмөр эрхлэлтийн түвшин, хүйсээр, улирлаар, хувиар



Ажиллах хүч 2018 оноос хойш бүүрч байгаа нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр дорвитой арга хэмжээ авах ёстойг харуулж байна.

**Өрхийн сарын дундаж нийт орлого, 2015 оны зэрэгцүүлэх үнээр 1.1 сая төгрөг болж өмнөх улирлаас 75.5 (6.2%) мянган төгрөгөөр буурчээ.**

Зураг 14. Өрхийн орлого, 2015 оны зэрэгцүүлэх үнээр, улирлаар, мянган төгрөгөөр



Өрхүүдийг мөнгөн орлогоор бүлэглэхэд, 300 мянган төгрөг хүртэлх орлого бүхий өрх өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 0.9 пунктээр буюу 8.6 мянган өрхөөр нэмэгдсэн байна. Энэ нь цар тахлын нөлөөлөл нийгмийн хамгийн эмзэг бүлэгт хүндээр тусч байгааг илтгэж байна.

Коронавируст халдварын тархалттай холбоотойгоор 2020 оны I, II улиралд манай улсын эдийн засагт тохиолдсон макро эдийн засгийн хямралын үзүүлэлтүүд нь өрхийн түвшинд харьцангуй сүүлд нөлөөлж, бүх нийтийн хөл хорионы үетэй давхцаж байгаа нь нэг талаас ЗГ-ын өрхийн хэрэглээг дэмжсэн шийдвэрүүд үр дүнгээ өгсөн, нөгөө талаас хөл хорио удаан хугацаагаар үргэлжлэх нь ажлын байрыг бууруулж, өрхийн бодит орлогод шууд нөлөөлснийг харуулж байна.

**Нийгмийн халамжийн сангаас 2021 оны 1 дүгээр сард давхардсан тоогоор 1.7 сая хүнд 155.6 тэрбум төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж, тусламж, үйлчилгээ, хөнгөлөлт олгов.**

Үүнээс, 120.1 тэрбум төгрөгийг 0-18 насны 1.2 сая хүүхдэд мөнгөн тэтгэмж болгон олгожээ. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад тэтгэмж авч буй хүүхдийн тоо 10.3 хувиар өссөн бол олгосон тэтгэмжийн хэмжээ 5.6 дахин нэмэгдсэн байна.

Нийгмийн халамжийн сангаас олгосон тэтгэвэр тэтгэмж, үйлчилгээний зардал нь 2020 оны I сард төсвийн зардлын 19.9 хувьтай тэнцэж байна.

## Эрүүл мэнд, гэмт хэрэг


**Улсын хэмжээнд 2021 оны 1 дүгээр сард амаржсан эхийн тоо өмнөх сараас 9.1 хувиар, нас баралт 5.6 хувиар буурлаа.** Манай улсын төрөлтийн түвшин I сард бага байх хандлагатай байдаг ч 2020 оны II сарыг тооцохгүй бол энэ сарын төрөлтийн түвшин нь сүүлийн 3 жилийн доторх хамгийн бага төрөлтийн түвшин бүхий сар болоод байна. Цаашлаад цар тахлын нөлөөлөл төрөлтийн түвшинд нөлөөлөх магадлалтай байна.

Сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагаа хязгаарлагдсанаас шалтгаалан амьсгалын замаар дамжих халдвар (коронавирусээс бусад) өнгөрсөн оны мөн үеэс 32.7 хувиар буурчээ.

**Бүртгэгдсэн гэмт хэрэг 2021 оны 1 дүгээр сард өмнөх сараас 24.2 хувиар өссөн байна.** Үүнд олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг 6.5 дахин нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн байна.

Нийт 651 гэр бүлийн хүчирхийллийн зөрчил бүртгэгдсэнээс 65.4 хувь нь Улаанбаатар хотод бүртгэгдсэн байна.

*Зураг 15. Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн зөрчил, өмнөх оны мөн үетэй харьцуулахад, хувиар*



Цар тахлын нөлөөгөөр хүмүүсийн хөл хөдөлгөөнийг хязгаарласантай холбогдон дэлхий нийтээр эмэгтэйчүүд, хүүхдүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэл нэмэгдсэн. Жишээлбэл, хамгийн анхны хөл хорио тогтоосон БНХАУ-ын Вухань хотод 2020 оны II сард өмнөх оны мөн үетэй харьцуулахад гэр бүлийн хүчирхийлэл 3 дахин, Франц улсад 32-36 хувиар, АНУ-д 21-35 хувиар тус тус нэмэгдсэн байна<sup>2</sup>. Харин манай улсад хөл хорио тогтоосон 2020 оны XI сард өмнөх жилийн мөн үеэс гэр бүлийн хүчирхийлэл 10.2 хувиар, XII сард 29.1 хувь, 2021 оны I сард 34.4 хувиар тус тус буурсан байна. Энэ нь нэг талаас эерэг үр дүн байгаа боловч гэр бүлийн хүчирхийлэл чимээгүй хэлбэрээр, хаалттай хаалганы цаана явагдаж байж болзошгүй юм.

Дэлгэрэнгүй мэдээллийг:

Та өөрийн гар утаснаас QR code уншуулагч аппликейшн ашиглан 2021 оны I сарын “Монгол улсын нийгэм, эдийн засгийн байдал – 1/2021” статистикийн бюллетень, сонирхсон салбарын дэлгэрэнгүй мэдээлэлтэй танилцана уу.



ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ  
ҮНДЭСНИЙ ТООЦОО, ШИНЖИЛГЭЭ СУДАЛГААНЫ ГАЗАР

---

<sup>2</sup> Usher K, Bhullar N, Durkin J, Gyamfi N, Jackson D. Family violence and COVID-19: Increased vulnerability and reduced options for support. *Int J Ment Health Nurs*. 2020;29(4):549-552. doi:10.1111/inm.12735